



ӨМГӨӨЛЛИЙН МИШЭЭЛ КОНСАЛТИНГ ХХК-ИЙН ГИШҮҮН
ӨМГӨӨЛӨГЧ
АМИНДАВААГИЙН ЗОРИГТБААТАР



2026 оны 01 сарын 02 өдөр

№ 06/05

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ТАНХИМ

Шинээр илэрсэн нөхцөл байдлын
улмаас шүүхийн шийдвэрийг дахин
хянуулах тухай

С.Эрдэнэцэцэг нь Баянзүрх дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтэст холбогдуулан Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргасан бөгөөд тус захиргааны хэрэгт А.Зоригтбаатар миний бие нэхэмжлэгчийн өмгөөлөгчөөр оролцсон.

Шүүхийн шийдвэр гарах үед нэхэмжлэгч болон хариуцагч нарт мэдэгдээгүй, мэдэгдэх боломжгүй байсан, хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий үйл баримт илэрсэн тул Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.1.1-д заасныг үндэслэн Монгол Улсын дээд шүүхийн Хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны 2023.12.11-ний өдрийн №96 дугаар тогтоолыг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас дахин хянуулах тухай энэхүү хүсэлтийг дараах үндэслэлээр гаргаж байна. Үүнд:

1. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.1.1-д заасан баримтын тухайд:

С.Эрдэнэцэцэг нь Баянзүрх дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтэст холбогдуулан Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргасан ба Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2023.05.25-ны өдрийн №0465 дугаар шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2023.08.23-ны өдрийн №0543 дугаар магадлалаар нэхэмжлэгч С.Эрдэнэцэцэгийн гаргасан нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж шийдвэрлэсэн. Харин Монгол Улсын дээд шүүхийн Хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны 2023.12.11-ний өдрийн №96 дугаар тогтоолоор шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулж, нэхэмжлэгчээс гаргасан “Г.Батчулуун болон Кредит монгол ББСБ ХХК-ийн хооронд байгуулсан барьцаат зээлийн гэрээний барьцаанд бүртгэсэн 2012.09.18-ны өдрийн болон 2013.03.22-ны өдрийн бүртгэлийг хүчингүй болгуулах” нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн.

Ийнхүү захиргааны маргаан шийдвэрлэгдсэний дараа С.Эрдэнэцэцэг нь “Г.Батчулуун болон Кредит монгол ББСБ ХХК-ийн хооронд байгуулагдсан 2012.09.18-ны өдрийн болон 2013.03.22-ны өдрийн барьцааны гэрээг хүчин төгөлдөр бусад тооцуулах” нэхэмжлэлийг Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхэд хандаж гаргасан ба тус иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад Кредит монгол ББСБ ХХК-ийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл нь маргаан эцэслэн шийдвэрлэгдэхээс өмнө хүчингүй болсон байсан нь тогтоогдоод байна.

Тухайлбал, Санхүүгийн зохицуулах хорооны 2023.10.02-ны өдрийн №505 дугаар тогтоолоор Кредит монгол ББСБ ХХК-ийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгон шийдвэрлэсэн байна.

2. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 133 дугаар зүйлийн 133.4-т заасан “үг нөхцөл байдал нь шийдвэрийг гаргахад хэрхэн нөлөөлсөн” буюу баримтын үр дагаврын тухайд:

2.1 Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “банк бус санхүүгийн үйл ажиллагаа” гэж Санхүүгийн зохицуулах хорооноос зөвшөөрөл авсан аж ахуйн нэгжийн эрхэлж байгаа энэ хуулийн 7.1.-д заасан үйлчилгээг”, мөн хуулийн 6 дугаар зүйл /Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх/-ийн 6.1-д “Банк бус санхүүгийн үйл ажиллагааг Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон зөвшөөрлийн дагуу Монгол Улсын болон гадаад улсын хуулийн этгээд эрхэлж болно”, 7 дугаар зүйл /Банк бус санхүүгийн үйл ажиллагаа/-ийн 7.1-д “Банк бус санхүүгийн үйл ажиллагаа гэж дараахь үйл ажиллагааг ойлгоно” гэж тус тус заасан ба Санхүүгийн зохицуулах хорооны 2023.10.02-ны өдрийн №505 дугаар тогтоолоор банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгон шийдвэрлэснээр Кредит монгол ББСБ ХХК нь банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх эрхгүй этгээд болох бөгөөд үйл ажиллагаа явуулах боломжгүй болсон байна.

2.2 Гуравдагч этгээд Кредит монгол ББСБ ХХК-ийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүчингүй болсон /СЗХ-ны 2023.10.02-ны №505/-оор гуравдагч этгээд нь үйл ажиллагаа явуулах боломжгүй болох бөгөөд Г.Батчулуунтай байгуулсан барьцааны гэрээ /2012.09.18, 2013.03.23/-ний эрх үүргийг хэрэгжүүлэх хууль зүйн боломжгүй байна. Өөрөөр хэлбэл, Кредит монгол ББСБ ХХК нь Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн хүрээнд Г.Батчулуунтай 2012.09.18, 2013.03.23-ны өдрүүдэд Зээлийн болон барьцааны гэрээг байгуулсан ба Санхүүгийн зохицуулах хорооны 2023.10.02-ны №505 дугаар тогтоолоор банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгосноор барьцааны эрхийг хэрэгжүүлэх боломжгүй болно.

2.3 Нөгөөтэйгүүр, Зөвшөөрлийн тухай хууль /2022 он/-ийн 6.4 дүгээр зүйл /Зөвшөөрлийг түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосны үр дагавар/-ийн 2-т “Зөвшөөрлийг хүчингүй болгосон нь тухайн зөвшөөрөл эзэмшигчээс зөвшөөрлийн дагуу эрхлэх үйл ажиллагаатай холбогдуулан бусадтай байгуулсан гэрээг цуцлах үндэслэл болно” гэж заасан ба Санхүүгийн зохицуулах хорооны 2023.10.02-ны өдрийн №505 дугаар тогтоолоор Кредит монгол ББСБ ХХК-ийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосноор тус зөвшөөрлийн хүрээнд Г.Батчулуунтай байгуулсан барьцааны гэрээ /2012.09.18, 2023.03.23/ цуцлагдах үндэслэл болно.

3. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 133 дугаар зүйлийн 133.4-т заасан “хэргийг дахин хянан шийдвэрлэх хууль ёсны үндэслэл” буюу хэргийг хянан шийдвэрлэх ач холбогдлын тухайд:

Санхүүгийн зохицуулах хорооны 2023.10.02-ны өдрийн №505 дугаар тогтоолоор гуравдагч этгээдийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгон шийдвэрлэсэн байсан болохыг Кредит монгол ББСБ ХХК-ийн төлөөлөгч, өмгөөлөгч нарын зүгээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүхэд огт мэдэгдээгүй ба харин ч банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд мэтээр хяналтын шатны шүүх хуралдаанд тайлбар, гомдол гаргаж оролцсон байдаг.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1-д “Хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийн шүүхэд гаргасан тайлбар бодит үнэнд нийцсэн, хэрэгт авагдсан нотлох баримтад үндэслэлдээн

байна" гэж заасан боловч гуравдагч этгээд Кредит монгол ББСБ ХХК-ийн төлөөлөгч, өмгөөлөгчийн зүгээс дээрх үүргээ эс биелүүлж, банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх эрхтэй хэвээр байгаа мэтээр шүүх хуралдаанд тайлбар гаргасан оролцсон байдаг. Өөрөөр хэлбэл, Тус захиргааны хэрэгт Кредит монгол гэх банк бус санхүүгийн байгууллага хэргийн оролцогч байхгүй болсон атал төлөөлөгч, өмгөөлөгч нарын зүгээс гуравдагч этгээдийг төлөөлөх эрхтэй мэтээр, банк бус санхүүгийн байгууллага хэвээр байгаа, эрх ашиг нь зөрчигдсөн мэтээр шүүхэд тайлбар, гомдол гаргасан нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн.

Хэрэв гуравдагч этгээд Кредит монгол ББСБ ХХК-ийн төлөөлөгч, өмгөөлөгчийн зүгээс банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүчингүй болсон тухайгаа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүхэд мэдэгдсэн бол Кредит монгол ББСБ ХХК нь барьцааны гэрээний эрхийг хэрэгжүүлэх боломжтой эсэх, Зөвшөөрлийн тухай хуулийн 6.4 дүгээр зүйлийн 2-т заасны дагуу барьцааны гэрээ цуцлагдах үр дагавар үүсэх эсэх, мөн гуравдагч этгээд цаашид үйл ажиллагаа явуулах боломжгүй болсноор барьцааны эрх хэрэгжих эсэх, гуравдагч этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөх эсэхэд хууль зүйн дүгнэлт бүрэн дүүрэн хийж маргааныг эцэслэн шийдвэрлэх боломж бүрдэх байсан.

Өөрөөр хэлбэл, Кредит монгол ББСБ ХХК-ийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүчингүй болсон нь дээрх байдлаар хэргийг хянан шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой баримт бөгөөд энэхүү үйл баримтад дүгнэлт хийснээр Г.Батчулуун болон Кредит монгол ББСБ ХХК нарын хооронд байгуулагдсан барьцааны гэрээ /2012.09.18, 2013.03.23/-ний бүртгэлийг хүчингүй болгуулах тухай нэхэмжлэлийн шаардлага хангагдаж шийдвэрлэгдэх боломжтой буюу ач холбогдолтой юм. Мөн С.Эрдэнэцэцэг нь шүүхийн шийдвэрээр өмчлөгчөөр тогтоогдсон, тус үл хөдлөх хөрөнгийн өөрийн хөрөнгөөр барьж гүйцээн 2016 оноос хойш өнөөдрийг хүртэл бодитоор амьдарч /өмчилж, эзэмшиж/ байгаа боловч өмчлөгчийн эрхээ хэрэгжүүлж чадалгүй өдийг хүрээд байгаа ба энэхүү хүсэлтэд хавсаргасан баримтыг шинээр илэрсэн нөхцөл байдалд тооцож хэргийг дахин хэлэлцэх нь шүүх маргааныг бүрэн дүүрэн, эцэслэн шийдвэрлэхэд ач холбогдолтой гэж үзэж байна.

Нөгөөтэйгүүр, Кредит монгол ББСБ ХХК-ийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүчингүй болсон тул цаашид үйл ажиллагаа явуулах боломжгүй болох бөгөөд тус хуулийн этгээдийг татан буулгах, эсхүл эрх хүлээн авагч томилогдох эсэх нь маргааныг хянан шийдвэрлэхэд ач холбогдолтой юм.

Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020.10.14-ний өдрийн №03069 дүгээр шийдвэрээр нэхэмжлэгч С.Эрдэнэцэцэг нь маргаан бүхий үл хөдлөх хөрөнгийн өмчлөгчөөр тогтоогдсон бөгөөд 6 жилийн хугацаанд өмчлөгчийн эрхээ хэрэгжүүлж чадахгүй байгаа ба Монгол Улсын Үндсэн хуульд заасан өмчлөх эрх нь зөрчигдсөөр байна. Мөн С.Эрдэнэцэцэг нь өмчлөх эрхээ баталгаажуулах, зөрчигдсөн эрхээ сэргээлгэхээр Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхэд нэхэмжлэл гаргасан боловч Кредит монгол ББСБ ХХК-ийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүчингүй болсон, хаягтаа оршин суудаггүй гэх үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн ба барьцааны гэрээтэй холбоотой маргааныг шийдвэрлүүлэх боломжгүй нөхцөл үүссэн.

Дээр дурьдсанчлан, Санхүүгийн зохицуулах хорооны 2023.10.02-ны өдрийн №505 дугаар тогтоолоор гуравдагч этгээд Кредит монгол ББСБ ХХК-ийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон шийдвэрлэсэн



энэхүү үйл баримт нь Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.1.1-д заасан "шүүхийн шийдвэр гарах үед хэргийн оролцогчид мэдэгдээгүй болон мэдэгдэх боломжгүй байсан баримт" бөгөөд хэргийг хянан шийдвэрлэх, хууль зүйн дүгнэлт хийхэд ач холбогдолтой байна.

Иймд Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 133 дугаар зүйлийн 133.5, 133.6-д тус тус заасны дагуу 2023.12.11-ний өдрийн №96 дугаар тогтоолыг хүчингүй болгож, С.Эрдэнэцэцэгийн нэхэмжлэлтэй захиргааны хэргийг ердийн журмаар шийдвэрлүүлж өгнө үү.

Жич: Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 132 дугаар зүйлийн 132.1-д заасан хугацааны дотор энэхүү хүсэлтийг гаргаж буй тухайд:

1. Санхүүгийн зохицуулах хороо шүүгчийн захирамжийн дагуу 2023.10.02-ны өдрийн №505 дугаар тогтоолыг 2025.10.14-ний өдрийн №9/3793 тоот албан бичгээр шүүхэд ирүүлсэн.
2. Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2025.11.28-ны өдрийн №51754 дүгээр захирамжаар ИХШХШТХ-ийн 65.1.9, 117.1-д заасан /хариуцагчийн хаяг тодорхойгүй/-ыг үндэслэн хэргийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн.
3. Нэхэмжлэгчийн өмгөөлөгч 2025.12.24-ний өдөр Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2025.11.28-ны өдрийн №51754 дүгээр захирамжийг гардан авахдаа Санхүүгийн зохицуулах хорооны 2023.10.02-ны өдрийн №505 дугаар тогтоолыг олж мэдсэн
4. С.Эрдэнэцэцэгийн нэхэмжлэлтэй иргэний хэрэг архивт орсны дараа буюу 2026.01.19-ний өдөр нэхэмжлэгчийн өмгөөлөгч Санхүүгийн зохицуулах хорооны 2023.10.02-ны өдрийн №505 дугаар тогтоолыг архивын "хуулбар үнэн тэмдэг"-ээр баталгаажуулан авсан.

Хүсэлтэд хавсаргасан баримт:

1. Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2025.11.28-ны өдрийн №51754 дүгээр "Хэргийг хэрэгсэхгүй болгох тухай" захирамж
2. "Хэрэг, хариу тайлбар, сөрөг нэхэмжлэл танилцуулсан тухай" шүүхийн баримт №6
3. Санхүүгийн зохицуулах хорооны 2025.10.14-ний өдрийн №9/3793 тоот албан бичиг
4. Санхүүгийн зохицуулах хорооны 2023.10.02-ны өдрийн №505 дугаар "Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай" тогтоол
5. Хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ

Хүндэтгэсэн,

ӨМГӨӨЛӨГЧ



А.ЗОРИГТБААТАР